



МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН
НИЙТ ШҮҮГЧИЙН ХУРАЛДААНЫ
ТОГТООЛ

2026 оны 05 сарын 15 өдөр

Дугаар 35

Улаанбаатар хот

Монголын ногоон намын дүрэм
/Шинэчилсэн найруулга/-ийг болон
намын дарга сонгосныг бүртгэх тухай

Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааныг Ерөнхий шүүгч Д.Ганзориг даргалж, Танхимын тэргүүн Д.Мөнхтуяа, Н.Баярмаа, шүүгч Б.Амарбаясгалан, Д.Батбаатар, Н.Батзориг, М.Батсуурь, Н.Батчимэг, Э.Золзаяа, М.Пүрэвсүрэн, П.Соёл-Эрдэнэ, С.Соёмбо-Эрдэнэ, Б.Ундрах, Б.Цогт, Ц.Цогт, Х.Эрдэнэсүвд нарын бүрэлдэхүүнтэй хийсэн хуралдаанаар,

Монголын ногоон намын дүрэм /Шинэчилсэн найруулга/-ийг болон намын дарга шинээр сонгосныг бүртгүүлж, улсын бүртгэлийн гэрчилгээнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай өргөдлийг шүүгч М.Батсуурийн илтгэснээр хэлэлцээд

ТОДОРХОЙЛОХ нь:

Монголын ногоон намын итгэмжлэгдсэн төлөөлөгч О.Батхүүгээс “Монголын ногоон нам нь Улс төрийн намын тухай хуульд нийцүүлэн дүрэмдээ өөрчлөлт оруулсан тул намын дүрмийг бүртгэж авахыг хүсье” гэсэн өргөдлийг нийт 90 хуудас баримт, 1 ширхэг хард диск, 18 ширхэг фото зургийн хамт 2026 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр;

Монголын ногоон намын итгэмжлэгдсэн төлөөлөгч Б.Анхбаяраас “Монголын ногоон намын ээлжит бус XX Их хурлаар намын даргаа шинээр сонгосон тул шинээр сонгогдсон даргыг бүртгэж, намын улсын бүртгэлийн гэрчилгээнд нэмэлт, өөрчлөлт оруулж өгнө үү” гэсэн өргөдлийг нийт 65 хуудас баримт, 18 ширхэг фото зургийн хамт 2026 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр Улсын дээд шүүхэд тус тус ирүүлсэн.

Монголын ногоон намын нэр бүхий гишүүнээс “... намын даргаар ажиллаж байсан О.Бум-Ялагч нь 2024 оны сонгуулийн үеэр намын тамга, тэмдэг, удирдлагын эрх мэдлийг бусдад шилжүүлсэн. Үүний улмаас намын хууль ёсны гишүүд албан ёсны мэдээлэлгүйгээр орхигдож, намын дотоод ардчилал, ил тод байдал алдагдсан нөхцөл байдал үүссэн. Мөн 2026 оны 03 дугаар сарын 31-ний өдөр Монголын ногоон намын нэрийг ашиглаж буй этгээдүүд 20 дугаар Их хурал нэртэй хурал зохион байгуулсан нь хүчин төгөлдөр бус гэж үзэж байна. 2024 оноос хойш гарсан удирдлага, тамга, тэмдэгтэй холбоотой өөрчлөлтийг хууль ёсны эсэхийг шалгах, 20 дугаар Их хурлыг хүчин төгөлдөр бус гэж үзэх, намын хууль ёсны гишүүдийн оролцоог хангаагүй шийдвэрүүдийг бүртгэхээс татгалзах, бүртгэлийн аливаа

өөрчлөлтийг хуульд нийцүүлэн шийдвэрлэж өгнө үү” гэх агуулгатай өргөдлийг 2026 оны 04 дүгээр сарын 08-ны өдөр Улсын дээд шүүхэд гаргасан байна.

Дээрх өргөдлүүд болон түүнд хавсаргасан баримтуудыг Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ болон Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 2024 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 06 дугаар тогтоолоор баталсан “Улс төрийн намын бүртгэл хөтлөх журам”-ын 2.5-д заасны дагуу шалгах ажиллагааг хэрэгжүүлж, сонсох ажиллагааг хийсэн ба тухайн ажиллагааны явцад 2026 оны 04 дүгээр сарын 16-ны өдөр 44 хуудас баримт, 2026 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр 32 хуудас баримт, 1 ширхэг флаш диск, 2 ширхэг фото зураг, 2026 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр 1 хуудас тайлбар зэргийг нэмэлтээр ирүүлснийг шалгаад, журмын 6.6-д зааснаар нийт шүүгчийн хуралдаанаар хэлэлцүүлэв.

ҮНДЭСЛЭХ нь:

Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаанаас Монголын ногоон намын дүрэм /Шинэчилсэн найруулга/ болон намын дарга сонгогдсоныг дараах үндэслэлээр бүртгэж шийдвэрлэлээ.

Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 2 дугаар зүйлд “Нам өөрийн дүрэм, хөтөлбөр, дотоод зохион байгуулалтыг Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-тай нийцүүлэх арга хэмжээг 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор авч хэрэгжүүлэх бөгөөд уг өөрчлөлтийг Улсын дээд шүүхэд 30 хоногийн дотор хүргүүлнэ” гэж заасан.

Монголын ногоон намаас дээрх хугацаанд нийт 4 удаа “дүрмийн өөрчлөлтийг бүртгүүлэх” өргөдлийг гаргасан байх бөгөөд Улсын дээд шүүхийн 2024 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 04/5450 дугаартай албан бичгээр “Их хурлыг товлон зарласан Бага хурлын бүрэлдэхүүн зөрчилтэй, баримт дутуу” гэж, мөн нийт шүүгчийн хуралдааны 2025 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 06 дугаар тогтоол, 2025 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн 44 дүгээр тогтоол, 2026 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 08 дугаар тогтоолоор “намын дүрмийн зарим зүйл, заалт хуулийн шаардлагад нийцээгүй” гэсэн үндэслэлээр бүртгэхээс татгалзаж шийдвэрлэсэн байна.

Тус нам нь 2026 оны 03 дугаар сарын 31-ний өдөр ээлжит бус XX Их хурлаа хуралдуулан намын дүрэм /Шинэчилсэн найруулга/-ээ баталж, бүртгүүлэх тухай өргөдлийг 2026 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр Улсын дээд шүүхэд дахин гаргасан нь Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн 2026 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн хуралдаанаар “зөрчлөө зассаны үндсэн дээр дахин нэг удаа 60 хоногийн дотор хандах”-аар тогтоосон хугацаанд, мөн Улс төрийн намын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3-т “Намын дүрэмд оруулсан нэмэлт, өөрчлөлт, намын даргыг томилсон шийдвэрийг 60 хоногийн дотор Улсын дээд шүүхэд албан ёсоор хүргүүлнэ” гэсэн заалтад нийцсэн байна.

Нэг. Намын ээлжит бус XX Их хурал болон 2026 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр хуралдсан Бага хурлын тухайд:

1.1. Монголын ногоон намын дүрэм (2012 он)-ийн 3.3.3-т “Намын ээлжит бус Их хурлыг намын Бага хурлын гишүүдийн ердийн олонхын шийдвэрээр хуралдуулж

болно”, 3.3.4-т “Намын Бага хурал 9 гишүүнээс бүрдэнэ. Намын Бага хурлыг тухайн хурлын гишүүдээс сонгогдсон хурлын тэргүүлэгчид удирдан явуулна” гэж заасан байна.

Монголын ногоон намын Бага хурлын 2026 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн “Ээлжит бус XX Их хурал товлон зарлах тухай” 1 дүгээр тогтоолд “Монголын ногоон намын ээлжит бус XX Их хурлыг 2026 оны 03 дугаар сарын 31-ний өдөр товлон зарласугай”, “Намын Их хурлын төлөөлөгчийн тоог тогтоох тухай” 2 дугаар тогтоолд “Намын ээлжит бус XX Их хурлыг 129 төлөөлөгчийн бүрэлдэхүүнтэйгээр хуралдуулсугай” гэж заасан байх ба тус тогтоолын хавсралтаар “Намын Их хурлын төлөөлөгчдийг сонгох журам”-ыг баталжээ.

Тус тогтоолуудыг баталсан Монголын ногоон намын Бага хуралд тус намын XIV Их хурлын 2024 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 7 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан 9 гишүүнээс 6 гишүүн оролцож, 66.6 хувийн ирцтэйгээр хуралдсан нь намын дүрэм (2012 он)-ийн 4.1-д “Шийдвэрлэх асуудлыг ил тодоор, ардчиллын зарчмаар хэлэлцэн олонхын саналаар хуулийн хүрээнд шийдвэрлэх бөгөөд цөөнхийн саналыг хүндэтгэн үзнэ” гэсэн намын үйл ажиллагааны зарчим болон 3.3.3-т “Намын ээлжит бус Их хурлыг намын Бага хурлын гишүүдийн ердийн олонхын шийдвэрээр хуралдуулж болно” гэж заасанд нийцсэн байна.

Монголын ногоон намын Бага хурлын 2026 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн хуралдаанаар баталсан “Намын Их хурлын төлөөлөгчдийг сонгох журам”-д “... Төлөөлөгч нь Монголын ногоон намын гишүүн байна, төлөөлөгчид нэр дэвшүүлэх, сонгох ажлыг намын хороод 2026 оны 03 дугаар сарын 24-ний өдрөөс 03 дугаар сарын 29-ний өдрийн хооронд явуулна, Их хурлын төлөөлөгчид намын гишүүн өөрөө нэр дэвшүүлэх эрхтэй, орон нутгаас 40 төлөөлөгч, Улаанбаатар хотоос 89 төлөөлөгч сонгоно, аймаг, нийслэлийн намын хороо гишүүдийг төлөөлөгчөөр сонгогдсоныг баталгаажуулж, Их хурал зохион байгуулах ажлын хэсэгт мэдэгдэнэ” гэж зохицуулжээ.

Тус намын Нийслэлийн намын хорооны 2026 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн “Төлөөлөгчийн нэрс хүргүүлэх тухай” 5 дугаартай албан бичгийн хавсралтаар 89 төлөөлөгч, Сэлэнгэ аймгийн намын хорооноос 7, Архангай аймгийн намын хорооноос 5, Булган, Баян-Өлгий, Баянхонгор болон Завхан аймгийн намын хорооноос тус бүр 7 төлөөлөгч Их хурлын төлөөлөгчөөр сонгогдсон талаар тус намын хороодын албан бичиг, хуралдааны тэмдэглэлийг баримтаар ирүүлсэн байх ба Монголын ногоон намын ээлжит бус XX Их хурлын 2026 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн “Их хурлын төлөөлөгчдийн бүрэн эрхийг баталгаажуулах тухай” 1 дүгээр тогтоолоор бүрэн эрхийг нь нийт төлөөлөгчдийн 100 хувийн саналаар баталгаажуулсан байна.

Монголын ногоон намын дүрэм (2012 он)-д ээлжит бус Их хурлыг хуралдуулахаас өмнө товлон зарлах тодорхой хугацааг заагаагүй бөгөөд 2026 оны 03 дугаар сарын 31-ний өдөр хуралдах ээлжит бус XX Их хурлын зарыг Өдрийн сонины 2026 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн №052(7905) дугаарт нийтлэн нийтэд мэдээлснээр хуралд оролцох намын гишүүд, төлөөлөгчдийн эрхийг хангасан байна. 2026 оны 03 дугаар сарын 31-ний өдөр танхимын хэлбэрээр зохион

байгуулагдсан ээлжит бус XX Их хуралд төлөөлөгчөөр сонгогдсон 129 төлөөлөгчөөс 97 нь биечлэн оролцсон нь хурлын тэмдэглэл, ирцийн бүртгэл, намын гишүүний үнэмлэх болон баримтаар ирүүлсэн дүрс бичлэг, фото зургаар тогтоогдож байна.

1.2. Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 17 дугаар зүйлийн 17.4-т “Намын төлөөллийн төв байгууллагын гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь санал гаргавал намын дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж болно. Энэ нэмэлт, өөрчлөлт нь намын дүрмийн гуравны нэгээс хэтрэхгүй байна” гэж хуульчилсан. Улсын дээд шүүхээс 2026 оны 04 дүгээр сарын 16-ны өдөр явуулсан сонсох ажиллагааны дараа Монголын ногоон намын Бага хурал гишүүдийнхээ гуравны хоёроос доошгүйн саналаар 2026 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр 66.6 хувийн ирцтэйгээр хуралдаж, Бага хурлын 2026 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн “Намын дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг батлах тухай” 4 дүгээр тогтоолыг баталсан нь тус хурлын тэмдэглэл, хуралдааны дүрс бичлэг, фото зургийн баримтаар тогтоогдож байна. Бага хурлын хуралдаанаар намын дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа хуралдаанд оролцсон саналын эрхтэй нийт гишүүдийн 100 хувийн саналаар, намын удирдах дээд байгууллага болох Их хурлын онцгой бүрэн эрхэд хамаарах агуулгатайгаас бусад зохицуулалтад нэмэлт, өөрчлөлт оруулан баталсан нь 2026 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн ээлжит бус XX Их хурлаар баталсан намын дүрэм /Шинэчилсэн найруулга/-ийн 6 зүйл, 20 хэсэг буюу 5.1 хувийг эзэлж байх тул Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 17 дугаар зүйлийн 17.4-т нийцжээ.

Монголын ногоон намын нэр бүхий гишүүнээс Улсын дээд шүүхэд ирүүлсэн өргөдлийг нийт шүүгчийн хуралдаанд танилцуулсан бөгөөд Монголын ногоон намын XX дугаар Их хурлыг товлон зарлаж, хуралдуулсан үйл ажиллагаа нь хууль зөрчсөн буюу хүчин төгөлдөр бус гэж үзэх үндэслэл баримтаар тогтоогдоогүй болно.

Мөн Монголын ногоон намын даргаар ажиллаж байсан О.Бум-Ялагчаас 2024 оны 07 дугаар сарын 23-ны өдөр тус намын Бага хуралд “... намын даргын үүрэгт ажлаас чөлөөлөгдөх, ... намын даргыг шинээр сонгох хүртэл хугацаанд намын гэрчилгээ, тамга хариуцан хадгалах, тамга түших албан тушаалтны томилж өгөх”-ийг хүссэн өргөдлийг гаргасан байна. Монголын ногоон намын Бага хурлын 2024 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн 24/10 дугаар тогтоолоор Ерөнхий нарийн бичгийн даргаар М.Төмөрийг томилж, 24/11 дүгээр тогтоолоор намын ээлжит бус XVI Их хурлыг товлон зарлаж, “... намын даргыг намын Их хурлаар хэлэлцэн сонгох хүртэл намын гэрчилгээ, тамгыг хариуцан хадгалах, намын тамга түшихийг Ерөнхий нарийн бичгийн дарга М.Төмөрт даалгасугай” гэж шийдвэрлэжээ. Тус намын Ерөнхий нарийн бичгийн дарга М.Төмөрөөс 2026 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр 26/29 дугаартай албан бичгээр “... 2024 оны 07 дугаар сарын 26-ны өдрөөс 2026 оны 03 дугаар сарын 31-ний өдөр хүртэлх буюу Монголын ногоон намын ээлжит бус XX Их хурлаар намын даргаар А.Ундраа сонгогдох хүртэлх хугацаанд тамга түшсэн” гэх тайлбарыг Улсын дээд шүүхэд ирүүлсэн ба Монголын ногоон намын дүрэм (2012)-ийн 3.6.5-д “Намын дарга Монголын ногоон намын гэрчилгээ, тамгыг хариуцан хадгална”, 3.7.3-т “Намын Ерөнхий нарийн бичгийн дарга Удирдах зөвлөлийн хурлыг даргалах ба намын өдөр тутмын ажлыг удирдан дараах ажил, үүргийг хариуцна. Үүнд: Шаардлагатай үед намын дарга нарын даргын хариуцсан ажил, үүргийг

гүйцэтгэх” гэж заасны дагуу намын даргын өөрийн гаргасан хүсэлт, намын Бага хурлын шийдвэрийн дагуу намын гэрчилгээ, тамгыг Ерөнхий нарийн бичгийн дарга хариуцсан хадгалсныг буруутгах үндэслэлгүй болохыг дурдав.

Хоёр. Намын даргыг сонгосон тухайд:

Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 15 дугаар зүйлийн 15.3-т “Намын дүрэмд оруулсан нэмэлт, өөрчлөлт, намын даргыг томилсон шийдвэрийг 60 хоногийн дотор Улсын дээд шүүхэд албан ёсоор хүргүүлнэ” гэж хуульчилсан.

2026 оны 03 дугаар сарын 31-ний өдөр хуралдсан Монголын ногоон намын ээлжит бус XX Их хурлын “Хэлэлцэх асуудлын дараалал батлах тухай” 5 дугаар тогтоолд “2.Монголын ногоон намын даргыг чөлөөлөх асуудлыг хэлэлцэх тухай, 3.Монголын ногоон намын даргыг сонгох тухай” асуудлыг баталсан байна. Намын даргыг бүртгүүлэхээр гаргасан өргөдөлд тус намын 2012 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн ээлжит бус Их хурлаар намын даргаар сонгогдож, Улсын дээд шүүхийн 2012 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 10 дугаар тогтоолоор бүртгэгдсэн О.Бум-Ялагчаас намын Бага хуралд 2024 оны 07 дугаар сарын 23-ны өдөр гаргасан “О.Бум-Ялагч миний бие Монголын ногоон намын даргын үүрэгт ажлаас чөлөөлөгдөх хүсэлтээ гаргаж байна. Хүсэлтийг хүлээн авч, намын даргын ажлаас чөлөөлнө үү” гэх, 2026 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр Улсын дээд шүүхэд гаргасан “Олзод овогтой Бум-Ялагч миний бие Монголын ногоон намын даргын үүрэгт ажлаас чөлөөлөгдөх хүсэлтээ 2024 оны 07 дугаар сарын 23-ны өдөр Бага хуралд гаргасан, ... ээлжит бус XX Их хурал 2026 оны 03 дугаар сарын 31-ний өдөр миний чөлөөлөгдөх тухай өргөдлийг хэлэлцэж, намын даргын үүрэгт ажлаас чөлөөлж шийдвэрлэсэн ...” гэх агуулга бүхий өргөдлийг тус тус эх хувиар нь ирүүлсэн.

О.Бум-Ялагчийн гаргасан өргөдлийн дагуу намын даргаас чөлөөлөх санал хураалт явуулж, Их хуралд оролцсон нийт 97 төлөөлөгчдийн 100 хувийн саналаар чөлөөлөгдөх өргөдлийг дэмжсэнийг Тооллогын комиссын 02 дугаар тогтоолд тусгаж, Их хурлын “Намын даргаас чөлөөлөх тухай” 8 дугаар тогтоолыг баталсан байна.

Монголын ногоон намын дүрмийн 3.6.2-т “Намын даргыг Их хурлаас сонгоно”, 2.2-т “Гишүүний эрх”, 2.2.1-д “Төр засгийн болон намын бүх шатны байгууллагад нэр дэвших, дэвшүүлэх, сонгогдох, сонгох” гэж заажээ. Тус намын ээлжит бус XX Их хуралд Ерөнхий нарийн бичгийн даргаас Агваанлуvsсангийн Ундрааг намын даргад нэр дэвшүүлэх саналыг хүргүүлсэн байх ба Их хурлын хуралдааны явцад намын даргад нэр дэвших, дэвшүүлэх өөр санал гараагүй тул нэр дэвших, дэвшүүлэх ажиллагааг хаасныг мэдэгдэж, намын даргыг сонгох нууц санал хураалт явуулсан болох нь Монголын ногоон намын Ерөнхий нарийн бичгийн даргын 2026 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 13 дугаартай албан бичиг, хуралдааны тэмдэглэл, дүрс бичлэгээр тогтоогдож байна. Нууц санал хураалтад тухайн Их хурлын нийт 97 төлөөлөгч оролцсоноос хүчингүй саналын хуудас 2, санал тэмдэглээгүй хуудас 6, хүчинтэй саналын хуудас 89 тоологдож, нийт төлөөлөгчдийн 91.8 хувийн саналаар Агваанлуvsсангийн Ундрааг намын даргаар сонгохыг дэмжсэнийг Тооллогын комиссын 3 дугаар тогтоолд тусгаж, Их хурлын 9 дүгээр тогтоолыг батлан гаргажээ.

Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 8 дугаар зүйлийн 8.1-д “Нам гишүүдээ намын удирдах байгууллага, албан тушаал, сонгуульд нэр дэвших, сонгох, томилоход аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхахгүй байж, тэгш боломж олгоно”, 8.3-т “Энэ хуулийн 16.1-д заасан байгууллагын болон намын бусад хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар асуудлыг шийдвэрлэх, цөөнхийн саналыг хэлэлцэх боломж олгож хүндэтгэн үзэх ...” гэж заасан ба Монголын ногоон намын ээлжит бус XX Их хурлын хуралдааны явцад намын даргад өөрийн нэрийг дэвшүүлэх болон бусдын нэрийг дэвшүүлэх талаарх саналыг чөлөөтэй, ил тод авсан, тус санал хураалтад оролцсон намын гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэсэн зэргээр санал хураалт хуулийн үндсэн зарчимд нийцсэн байх тул намын даргаар А.Ундрааг сонгосныг бүртгэх нь зүйтэй гэж үзлээ.

Гурав. Намын дүрэм /Шинэчилсэн найруулга/-ийн тухайд:

3.1.Монголын ногоон намын ээлжит бус Их хурал 2026 оны 03 дугаар сарын 31-ний өдөр хуралдаж, намын дүрэм /Шинэчилсэн найруулга/-ыг батлах асуудлыг хэлэлцэж, ил санал хураалтаар хуралдаанд оролцсон 97 төлөөлөгчийн 100 хувийн саналаар дэмжин баталсан нь Тооллогын комиссын 1 дүгээр тогтоол, ээлжит бус Их хурлын “Намын дүрмийн шинэчилсэн найруулга батлах тухай” 7 дугаар тогтоол, хурлын тэмдэглэл, дүрс бичлэг зэрэг баримтаар тогтоогдож байна.

3.2.Улсын дээд шүүхийн 2026 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 08 дугаар тогтоолд заасан “Хяналтын ерөнхий хорооны бүрэлдэхүүний тоог тодорхой бус тусгасан, тус хорооны гишүүний орон гарч, сул орон тоо үүссэн тохиолдолд уг орон тоог “нөхөн сонгох” эрхийг Хяналтын ерөнхий хороо эдлэхээр буюу хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.2-т заасантай нийцэхгүй байдлаар намын дүрэмд тусгасан, дүрмийн 26.1.11-д “Намын салбар болон бүтцийн нэгж байгуулах, татан буулгах асуудлыг намын дүрэмд заасны дагуу шийдвэрлэх нарийвчилсан журмыг намын дүрэмд нийцүүлэн батлах” гэсэн нь хуулийн шаардлагыг зөрчсөн буюу намын дүрэмд тодорхой тусгахыг шаардсан байхад дүрэмд тусгахгүйгээр тусдаа журам гаргах агуулгаар дүрэмд тусгасан, хуулийн 42.1-д заасан арга хэмжээг авахад хүргэсэн алдаа, зөрчлийг намын орон нутгийн салбар нэгж гаргах тохиолдолд зохицуулах заалтыг нам дүрэмдээ тусгана” гэсэн байхад намын дүрэмд тусгаагүй, Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүний тоог намын дүрэмд 15, хурлын тэмдэглэлд 21 гэж зөрүүтэй тусгасан, намын бодлогын судалгааны байгууллагын үйл ажиллагаанд төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэгээс зарцуулах хувь хэмжээг хуульд нийцүүлэн тогтоох асуудлыг орхигдуулсан” зэрэг алдаа зөрчлүүд дараах байдлаар арилсан байна. Тухайлбал,

3.2.1.Намын дүрэм /Шинэчилсэн найруулга/-ийн 32.3-т “Хяналтын ерөнхий хороог намын Их хурлаас 7 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр нэр дэвшүүлж 4 жилийн хугацаагаар, ... нууц санал хураалтаар сонгоно. Хяналтын ерөнхий хорооны гишүүний орон гарвал түүнийг хууль, дүрэмд заасны дагуу Их хурлаас нөхөн сонгоно” гэж тогтоолд дурдсан зөрчлийг арилган, хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.2-т заасан намын хяналтын байгууллагын бүрэлдэхүүнийг Их хурлаас сонгох хуулийн зохицуулалтад нийцүүлэн зохицуулжээ.

3.2.2.Дүрмийн 8.2-т “Намын анхан шатны байгууллага нь нийслэлд дүүргийн намын хороо, хорооны намын хороо, үүр, аймагт сумын намын хороо, үүр, багийн намын үүр байна. Шаардлагатай бол намын үүрт намын хэсэг байгуулна”, 11.1-д “Намын дунд шатны байгууллага гэдэгт аймаг, нийслэлийн намын байгууллагыг ойлгоно” гэж, 26.1-д “Удирдах зөвлөл дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:” гээд 26.1.11.Намын салбар болон бүтцийн нэгж байгуулах, татан буулгах асуудлыг Намын дүрэмд заасны дагуу шийдвэрлэх; 26.1.15.Намын салбар болон бүтцийн нэгжийг Монгол Улсын Засаг захиргааны нэгжид үндэслэн байгуулах, хууль тогтоомжид заасны дагуу уг нэгжид өөрчлөлт орсон тохиолдолд татан буулгах, өөрчлөн байгуулах; гэж заасан. Тус намын Ерөнхий нарийн бичгийн даргаас 2026 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 26/29 дугаартай “Тайлбар хүргүүлэх тухай” албан бичигт “Намын анхан шатны байгууллагыг засаг захиргааны нэгжээр баг, хороонд байгуулна. Аймаг, нийслэлийн намын хороог дүрмийн 26.1.15-д зааснаар засаг захиргааны нэгжээр аймаг, нийслэлд Удирдах зөвлөлөөс байгуулна. Татан буулгах үндэслэл нь засаг, захиргааны нэгжид өөрчлөлт орсон бол татан буугдана” гэж тайлбарласан байна.

3.2.3.Дүрмийн 45.7-д “Хуулиар хориглосон этгээдээс хандив хүлээн авснаа мэдсэнээс хойш ажлын 10 өдрийн дотор хандивлагч болон сонгуулийн төв байгууллагад мэдэгдэж хандивыг сонгуулийн төв байгууллагад шилжүүлэх бөгөөд энэ талаар санхүүгийн тайланд холбогдох засвар, өөрчлөлтийг оруулан Сонгуулийн төв байгууллагад хүргүүлнэ”, 45.9-д “Энэ дүрмийн 45.7-д заасан үүргээ биелүүлээгүй, мөн дүрмийн 45.8-д заасан зөрчлийг гаргасан этгээдэд намын дүрэмд заасан сахилгын хариуцлага хүлээлгэнэ. Хэрэв намын орон нутгийн нэгжийн холбогдох албан тушаалтан уг зөрчлийг гаргасан тохиолдолд дүрэмд заасан сахилгын хариуцлага хүлээлгэнэ” гэж хуулийн 42 дугаар зүйлийн 42.4-т заасны дагуу намын дүрэмд тодорхой зохицуулалтыг тусгасан.

3.2.4.Дүрмийн 25.1-д “Удирдах зөвлөлийг Монголын ногоон намын Ерөнхий нарийн бичгийн дарга, нарийн бичгийн даргыг оролцуулан 9 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр Бага хурлаас нууц санал хураалтаар намын Их хурлын бүрэн эрхийн хугацаатай адил буюу 4 жилийн хугацаагаар сонгоно” гэж заасан.

3.2.5.Намын дүрмийн 40.3-т “Намд олгосон төрийн санхүүжилтийн 50 хувийг Улс төрийн намын тухай хуульд заасан зориулалт, хувь хэмжээний дагуу зарцуулах бөгөөд зорилтот санхүүжилт тус бүрийн гуравны нэгээс доошгүй хувийг бодлогын судалгааны байгууллагын үйл ажиллагаанд зарцуулна. ...” гэж заасан. Тус заалтад Улс төрийн намын тухай хуульд заасан хувь хэмжээний дагуу зарцуулах талаар болон бодлогын судалгааны байгууллагын үйл ажиллагаанд зорилтот санхүүжилт тус бүрийн гуравны нэгээс доошгүй хувийг зарцуулахаар зааж, Улс төрийн намын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3, 26.4-т заасан зохицуулалтыг тодорхойлон тусгасан байна.

Иймд, Монголын ногоон намын 2026 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн ээлжит бус XX Их хурлын 9 дүгээр тогтоолоор намын даргаар Агваанлуvsсангийн Ундрааг сонгосныг болон тус хурлын 7 дугаар тогтоолоор баталсан намын дүрэм /Шинэчилсэн найруулга/, түүнд Бага хурлын 2026 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн 4 дүгээр тогтоолоор оруулсан нэмэлт, өөрчлөлт нь Улс төрийн намын тухай

хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 15 дугаар зүйлд заасан намын дүрэмд тавигдах нийтлэг шаардлага болон намын дүрмээр тусгайлан зохицуулах асуудлыг тусгасан, бүртгэхээс татгалзах ноцтой зөрчил байхгүй тул намын дүрмийг бүхэлд нь бүртгэхээр тогтов.

Монголын ногоон намын итгэмжлэгдсэн төлөөлөгч Б.Анхбаяраас гаргасан өргөдөлд “... улсын бүртгэлийн гэрчилгээнд нэмэлт, өөрчлөлт оруулж өгнө үү” гэсэн байх ба Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 15 дугаар зүйлийн 15.4-т “Улсын дээд шүүхийн Тамгын газар нь энэ хуулийн 15.3-т заасан шийдвэртэй холбоотой мэдээллийг бүртгэж, энэ тухай нийтэд мэдээлж, сонгуулийн төв байгууллагад хүргүүлнэ” гэж заасны дагуу Улсын дээд шүүхийн Тамгын газар улсын бүртгэлийн гэрчилгээнд намын даргын бүртгэлтэй холбоотой нэмэлтийг тусгах нь зүйтэй болохыг дурдав.

Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 25 дугаар зүйлийн 25.8.8, 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэгт заасныг тус тус удирдлага болгон ТОГТООХ нь:

1.Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 15 дугаар зүйлийн 15.3, 15.5 дахь хэсгийг баримтлан Монголын ногоон намын дүрэм /Шинэчилсэн найруулга/-ийг бүртгэсүгэй.

2.Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 15 дугаар зүйлийн 15.5, 17 дугаар зүйлийн 17.6-д заасныг баримтлан намын даргаар Агваанлуvsангийн Ундрааг бүртгэсүгэй.

ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ,
ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

Д.ГАНЗОРИГ

ИЛТГЭГЧ ШҮҮГЧ

М.БАТСУУРЬ